

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА

**БҮРД СУМЫН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА**

1 хувийг СХДАА-д

1 хувийг Бүрд сумын Засаг дарга-д

2023 он



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 29/07

Арвайхээр сум

Бүрд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тухай

Нэг. Ерөнхий зүйл

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдөр баталсан 29/07 тоот удирдамжийн дагуу Бүрд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд "Төсвийн тухай", "Нягтлан бодох бүртгэлийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай", Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам болон бусад холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд холбогдох хууль, удирдах дээд байгууллагуудын тогтоол, шийдвэр, заавар, журмуудын хэрэгжилтийг шалгаж, үнэлэлт дүгнэлт өгч ажиллалаа.

Шалгалт явуулахдаа санхүүгийн баримтыг банкны хуулга болон анхан шатны баримтууд, тайлан тооцоо бодсон актуудтай тулган баталгаажуулах, асууж тодруулах хэлбэрээр явууллаа.

Хоёр. Шалгалтын бүрэлдэхүүн, хугацаа

Шалгалтыг аудитор, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Б.Пүрэвсүрэн 2023 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн хийж гүйцэтгэлээ.

Гурав. Шалгалтад хамрагдсан объектын талаарх товч мэдээлэл

Бүрд сумын орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг сумын Засаг даргын захирамжаар захиран зарцуулдаг байна. Шалгагдсан хугацааны баримт дээр нэгдүгээр гарын үсгийг сумын Засаг дарга М.Мөнхбаяр, хоёрдугаар гарын үсгийг нягтлан бодогч Г.Анхтөр нар зурж хөрөнгийг захиран зарцуулж иржээ.

Дөрөв. Өмнөх шалгалтын талаар

Төрийн аудитын байгууллагаас аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийж зөрчилгүй дүгнэлтийг өгчээ.

692907015

Тогтвортой амьжиргаа төслөөс сумын орон нутгийн хөгжлийн сангийн жилийн гүйцэтгэлийн үнэлгээг “олон нийтийн оролцоо”, “төлөвлөлт”, “ил тод байдал”, “хэрэгжилт”, “хяналт, шинжилгээ-үнэлгээ”, “өмчлөл” гэсэн 6 бүлгийн нийт 34-35 үзүүлэлтээр үнэлдэг бөгөөд 2022 оны жилийн гүйцэтгэлийг 67.2 хувиар үнэлж, 40,306,704 (дөчин сая гурван зуун зургаан мянга долоон зуун дөрөв) төгрөгийн санхүүжилт олгожээ.

Тав. Шалгалтад хамрагдсан асуудлын талаар

5.1. Санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан заавар журмын хэрэгжилт:

2021 онд Сангийн сайдын 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 228 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг төлөвлөх, батлах, санхүүжүүлэх, хэрэгжүүлэх, бүртгэх, тайлагнах, хяналт тавих үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж байсан бөгөөд Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам” шинэчлэн батлагдсанаар мөрдөж ажилласан.

Сангийн журмын 5.2-т “Баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн болон малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг дараах хэлбэрээр явуулна”. Үүнд: 5.2.1-д “санал асуулгын хуудас”, 5.2.2-т “бүлгийн ярилцлага (орон нутгийн иргэд өөрсдөд тулгамдаж буй асуудлаар нийтийн ашиг сонирхлыг илэрхийлж сайн дурын үндсэн дээр нэгдсэн бүлгийн зохион байгуулалт)”, 5.2.3.-т “цахим хэлбэр болон техник, технологийн дэвшилтэт бусад арга хэлбэр” гэсэн заалтын дагуу сумын 5 багийн 847 өрхийг төлөөлж, нийт өрхийн 36.26 хувь буюу 313 өрхөд санал асуулгын хуудсыг хүргүүлж, 2022 онд орон нутгийн хөгжлийн сангаас хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг авсан. Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 5 дугаар зүйлийн 5.3-д “энэ журмын 5.2.1-д заасан хэлбэрээр санал авахдаа энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтыг баг, хорооны иргэдэд хүргүүлж, бүртгэл хөтлөн ирсэн саналыг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу бүртгэж нэгтгэнэ.

” гэж заасан бөгөөд энэхүү заалтын хүрээнд өрхөд саналын хуудас хүргүүлсэн тоог нийт өрхийн тоонд харьцуулан хамрагдалтыг багуудаар авч үзвэл:

д/д	Багийн нэр	Өрхийн тоо	Нийт саналын хуудас хүргүүлсэн өрхийн тоо	Саналын хуудас хүлээн авсан өрхийн эзлэх дундаж хувь
1	Аржаргалант	172	72	41.8%
2	Их борогдойн	201	53	26.3%
3	Донгит	169	68	40.2%
4	Ар хөшөөт	171	40	23.3%
5	Онгон	134	80	59.7%
	Дүн	847	313	36.26%

Дээрх хүснэгтээс үзэхэд анхан шатны санал хураалтын хүрээнд өрхүүдэд төдийлөн хангалттай саналын хуудсыг хүргээгүй байна.

2022 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналд Аржаргалант багийн иргэдээс ирүүлсэн саналын хуудсанд боловсруулалт хийж үзэхэд:

д/д	Саналын эрэмбийн дараалал	Иргэдийн саналын тоо	Хяналт хийсэн тоо	Зөрүү
1	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын биеийн тамир тоглоомын талбай	43	50	7
2	ЕБС-ийн өмнөх хатуу хучилттай талбайн засвар	41	29	12
3	Сумын төвийн хатуу хучилттай авто замын засвар	39	16	23
4	Газар зүйн нэрийн зураглал хийлгэх тогтоох	32	1	31
5	Оготно устгах	29	24	5
6	Спорт заалны шалны засвар	27	1	26
7	Соёлын төвийг хайсжуулах	23	18	5
8	Их борогдойн засвар	21	16	5
9	Цэцэрлэгт хүрээлэнгийн засвар	19	10	9
10	Соёлын төвийн орон нутгийн судлах танхим үзэсгэлэнгийн танхимыг зориулалтын дагуу тохижуулах	17	20	-3
11	Чигчий хорооллын гэрэлтүүлэг	13	-	13
12	Сумын төвийн явган хүний замын тохижилт		15	-15
13	Эрүүл мэндийн төвийн гал тогооны тоног төхөөрөмж шинэчлэх		1	-1
14	Стандарт хангасан архивын өрөө		3	-3

саналуудын тоо зөрүүтэй байна. Энэ нь иргэд саналын хуудсыг бүрэн гүйцэд бөглөдөггүй, саналаа тодорхой бичдэггүйгээс саналыг утгаар нь ойлгож нэгтгэдэг, бүлгийн ярилцлагын саналаа гар өргүүлэн шууд нэмж тооцдогтой холбоотой. Иймд санал авах хуудсыг зөв бөглүүлэхэд анхаарч, хэрхэн бөглөх тухай зааварчилгаа өгөх, тухайн багаас ямар ажил хийх шаардлагатай байгаа талаарх саналыг хуудсандаа бөглүүлж бичүүлэх, түүнийгээ сумын Засаг даргад уламжлан ажиллах хэрэгтэй. Орон нутгийн хөгжлийн сангийн төслийн саналаа хэлэлцэж, иргэдийн төлөөлөө сонгон багийн ИНХ-д оролцуулсан боловч хуралдааны тэмдэглэлд хэдэн

иргэн цаасаар болон амаар саналаа өгч оролцсон, иргэдийн санал хүсэлтүүд хурлын тэмдэглэлд тодорхой бичигдээгүй зэргээс харахад төслийн сонгон шалгаруулалтыг ор нэр төдий хийдэг, ажилдаа хайнга хариуцлагагүй хандаж иржээ.

Иргэдээс ирүүлсэн нийт саналын жагсаалтыг хэлэлцэх, санал хураах хурлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.10 -т заасны дагуу хүчин төгөлдөр ирцтэйгээр 5 дугаар сард багтаан зохион байгуулна гэж "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу багуудын иргэдийн нийтийн хурлыг 2022 оны 05 дугаар сарын 15-25-ны өдрүүдэд зохион байгуулж, ИНХ-д оролцогчдоор гарын үсэг зуруулж, хуралдааны тэмдэглэл үйлдэж, иргэдээс ирсэн санал, тухайн хурлын үеэр дэвшүүлсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний санал бүрийг дэмжиж буй эсэхийг ил тод санал хурааж, дэмжиж санал өгсөн иргэдийн тоог баг, хорооны сонгуулийн насны иргэдийн тоонд харьцуулсан харьцаагаар эрэмбэлсэн тэргүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналын жагсаалтыг ИНХ-ын тогтоолоор баталсан. Үүнд: Ар жаргалант баг 11, Их борогдой 8, Донгит 5, Ар хөшөөт 11, Онгон 9 ажлуудад санал өгсөнийг эрэмбэлэн нэн тэргүүнд хийх шаардлагатай нийт 5 саналыг сумын Засаг даргад хүргүүлжээ.

Сумын Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн а/74 дүгээр захирамжаар орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний саналыг нэгтгэн эрэмбэлэх 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ажлын хэсэг багуудын ИНХ-ын тогтоолоор батлагдаж, ирүүлсэн саналуудыг эрэмбэлэн, нэгдсэн жагсаалтыг сумын Засаг даргад хүргүүлж, 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн 3 дугаар хурлаар хэлэлцүүлэн 15 шинээр эхлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний жагсаалтыг сумын ИТХурлын 07/04 дүгээр тогтоолоор батлуулан ажилласан.

Сангийн журмын 3.2-т аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын чиг үүрэг: 3.2.2-т "Тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих" гэсэн заалтын хүрээнд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн "Иргэний хяналтын баг байгуулах тухай" 27 дугаар тогтоолоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийгдэж буй бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэл тоо хэмжээ, чанар аюулгүй байдалд хяналт тавих чиг үүрэг бүхий багийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 2022 оны 06 дугаар сарын 15-нд сумын ИТХ-ын даргаар батлуулсан "Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бүтээн байгуулалтын гүйцэтгэлд хяналт хийх"

удирдамжийн хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын талбай, цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбай болон соёлын төвийн хайс зэрэг ажлуудыг гүйцэтгэж буй явцтай танилцжээ. 2022 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн удирдамжаар ЕБС-ийн биеийн тамирын талбай, цэцэрлэгийн тоглоомын талбай, музейн засварын ажил, чигчий хорооллын гэрэлтүүлэг зэрэг ажлуудад иргэний хяналт хийж, 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулсан байна.

Сангийн журмын 9.5-д "орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, зарцуулалт, гүйцэтгэл, тайлагналт, бүртгэлийн явц, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Журам шинэчлэн батлах тухай" 206 дугаар тогтоол, энэхүү тогтоолын хавсралтаар батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д зааснаар аймгийн захиргааны байгууллагууд жил бүр хийнэ" гэж заасан ч аймгийн ЗДТГ-ын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдээгүй. ?

Сангийн журмын 9.2-т "Сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга нь орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн тайланг гаргаж, дараа оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлэх ба энэ журмын 9.9-д заасан мэдээллийг багтаана" гэж заасны дагуу орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл зарцуулалтын тайланг нэгтгэсэн боловч аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст хугацаанд нь хүргүүлээгүй байна. ^

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилтийг сайжруулах үүднээс хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан дүгнэлтийг сумын ИТХурлаар хэлэлцүүлж байх шаардлагатай.

5.2. Тухайн сангийн жилийн батлагдсан төсөв, санхүүжилт, орлого бүрдүүлэлт, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх:

Сангийн журмын 2.8-д "Энэ журмын 2.5, 2.6 болон 2.7-д заасан орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ бүрийг тухайн шатны ИТХ хэлэлцэн батална.", 2.9-д "Аймаг, нийслэл, сум,

дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн төсөвт орсон өөрчлөлтийг орон нутгийн төсвийн тодотголын төсөлд тусган "Төсвийн тухай" хуульд заасны дагуу боловсруулж батлуулна" гэсэн заалтын дагуу сумын ИТХурлын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн "Бүрд сумын 2022 оны төсөв батлах тухай" 07/04 дүгээр тогтоолоор Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг 415,612,500 (дөрвөн зуун арван таван сая зургаан зуун арван хоёр мянга таван зуу) төгрөгөөр баталсан. Сумын ИТХурлын 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 09/08 дугаар "Сумын 2022 оны төсөвт тодотгол хийх тухай" тогтоолоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг 404,234,500 (дөрвөн зуун дөрвөн сая хоёр зуун гучин дөрвөн мянга таван зуу) төгрөг болгож, 11,378,000 (арван нэгэн сая гурван зуун далан найман мянга) төгрөгөөр багасган тодотгосон байна. Тодотгосон төсөв:

(төг)

№	Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний нэр	2022 онд санхүүжих	Тодотгосон төсөв
1	Хүүхдийн тоглоомын талбайн үлдэгдэл санхүүжилт	5,000,000	
2	Цэцэрлэгийн тоглоомын талбай	20,000,000	
3	ЕБСургуулийн биеийн тамирын талбай	12,000,000	
4	Чигчий хорооллын гэрэлтүүлэг	10,000,000	
5	Иргэний танхим 2 дугаар баг	60,000,000	622,000
6	Орон нутгийн музейн засвар	7,612,500	
7	Соёлын төвийн хайс	10,000,000	
8	Сумын газарзүйн нэрийн зураг	12,000,000	-12,000,000
9	Цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт	9,000,000	
10	Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах /Худаг Зш/	75,000,000	
11	Малын тэжээлийн ургамал тариалах тоног төхөөрөмж худалдан авах	133,000,000	
12	Борогдойн Донгит багт мэрэгч устгах	15,000,000	
13	Аржаргалант Архөшөөт багт мэрэгч устгах	15,000,000	
14	МЭТасгийн тоног төхөөрөмж	20,000,000	
15	Зохиомол хээлтүүлгийн багаж хэрэгсэл худалдан ваах	5,000,000	
16	Мал эзэмэгжүүлэх зардал	7,000,000	
		415,612,500	11,378,000

Орон нутгийн хөгжлийн сангийн дансны эхний үлдэгдэл 7,936,181 (долоон сая есөн зуун гучин зургаан мянга нэг зуун наян нэг) төгрөг, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 107,575,700 (нэг зуун долоон сая таван зуун далан таван мянга долоон зуу) төгрөг, Тогтвортой амьжиргаа-3 төслөөс 19,158,948 (арван есөн сая нэг зуун тавин найман мянга есөн зуун дөчин найм) төгрөг, татварын давсан орлогоос санхүүжих 117,340,200.00 (нэг зуун арван долоон сая гурван зуун дөчин мянга хоёр зуу) төгрөг, нийт 244,074,848 (хоёр зуун дөчин дөрвөн мянга далан дөрвөн мянга найман зуун дөчин найм) төгрөгийн санхүүжилт авч, 184,945,875 (нэг зуун наян

дөрвөн сая есөн зуун дөчин таван мянга найман зуун далан тав) төгрөгийн төсвийг зориулалтын дагуу зарцуулжээ.

5.3. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, өр авлага, тооцоо бодолт, санхүүгийн тайлан гаргалт:

Сар бүр харилцахын боловсруулалт хийж, жилийн эцсээр ажил тус бүрээр гүйцэтгэлийн тайлан гаргаж, дараа онд санхүүжигдэхээр үлдсэн санхүүжилтийн үлдэгдэл 67,065,154 (жаран долоон сая жаран таван мянга нэг зуун тавин дөрөв) төгрөгийг тайланд тусгаж, 2022 онд орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдсэн хөрөнгө оруулалтын үлдэгдлийг 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Техник хаус ХХК-ийн ХААН банкны 5031651972 тоот дансанд малын тэжээлийн ургамал тариалах тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын үлдэгдэл санхүүжилт 15,000,000 (арван таван сая) төгрөгийг, 02 дугаар сарын 09-нд мөн тус компанид 40,200,000 (дөчин сая хоёр зуун мянга) төгрөг, нийт 55,200,000 (тавин таван сая хоёр зуун мянга) төгрөгийг 2023 онд гүйцээж санхүүжүүлжээ.

2022 оны эцэст 61,700,000 (жаран нэгэн сая долоон зуун мянга) төгрөгийн санхүүжилтийн өглөгийг Техник хаус ХХК-тай тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан.

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд орон нутгийн хөгжлийн сангийн орлого, зарлагыг бүрэн тусгаж өгчээ. Орон нутгийн хөгжлийн сангийн 2022 оны санхүүгийн баримтыг шалгахад анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлжээ. Соёлын төв "Музейн засварын ажил"-д 8,100,000 (найман сая нэг зуу) мянга төгрөгийг үндсэн хөрөнгийн барилга байгууламжид, гаднах талбайг хайсжуулах 10,000,000 (арван сая) төгрөгийг бусад үндсэн хөрөнгийн зардалд капиталжуулан бүртгэсэн. Засаг даргын Тамгын газар газар тариалангийн тракторын 139,500,000 (нэг зуун гучин есөн сая таван мянга) төгрөгийг авто тээврийн хэрэгсэл, хүүхдийн тоглоомын талбай 20,000,000 (хорин сая) төгрөг болон чигчий хорооллын гэрэлтүүлэг 9,975,000 (есөн сая есөн зуун далан таван мянга) төгрөгийн хөрөнгүүдийг орлогод авч капиталжуулсан.

5.4. Төсвийн хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт:

2022 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шинээр хийхээр 15 төрлийн ажил төлөвлөснөөс 2 ажилд тендер сонгон шалгаруулалтаар, 9 ажлыг шууд гэрээ байгуулж, 4 ажлыг дараа онд гүйцэтгэхээр шилжүүлжээ.

Дээрх ажлуудыг хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах болон хүлээн авах үүрэг бүхий үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэг гаргуулсан боловч ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн

мэдэгдлээ гаргахдаа үнэлгээний хороог томилсон эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулалтыг огт хийлгүүлээгүй зөрчил илэрлээ.

5.5. Тухайн сангаас хөрөнгө зарцуулах талаар гарсан захирамж, тушаал шийдвэр, гадны харилцагч байгууллага хүмүүстэй хийсэн гэрээ, түүний хэрэгжилт, үр дүн:

Өсөх-Ирээдүй бүлэгээр "Соёлын төвийг хайсжуулах" ажил гүйцэтгүүлэхээр 2022 оны 05 дугаар сарын 31-нд ажил гүйцэтгэх гэрээ, Үнэмч бүлгээр "ЕБС-ийн биеийн тамирын гадна талбайн тохижилтийн ажил"-ийг гүйцэтгүүлэхээр 2022 оны 05 дугаар сарын 20-ны өдөр ажил гүйцэтгэх гэрээ, 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдөр "Чигчий хорооллын гэрэлтүүлэг"-ийн ажил гүйцэтгэх гэрээ, "СӨББ гадаах тоглоомын талбай" 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээ, 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр "Музейн засварын ажил" гүйцэтгүүлэхээр иргэнтэй байгуулсан гэрээнүүдэд гэрээний дугаар байхгүй байгааг цаашид анхаарч, ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулахдаа нэгдсэн дугаар өгч гэрээг байгуулан ажиллахыг анхаарууллаа.

5.6. Тухайн оны Орон нутгийн хөгжлийн сангийн зорилт, хэрэгжилт, үр дүн:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн үйл ажиллагааг Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.1.1-т "орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь "Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай" хуулийн 6 дугаар зүйлд заасан урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй уялдсан байх" гэсэн заалтын хэрэгжилтийг шалгахад сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулжээ.

Зургаа. Шалгагдсан байгууллага, аж ахуйн нэгжид өгсөн дүгнэлт, шийдвэрлэвэл зохих асуудал


Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн үйл ажиллагаа, худалдан авах ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа хэвийн явагдаж иржээ. Гэвч тендерийн үнэлгээний хорооны гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй гэсэн мэдэгдлээ гаргахдаа удирдах дээд албан тушаалтнаар баталгаажуулдаггүй, тендерийн нээлтийн тэмдэглэлд үнэлгээний хорооны гишүүдийн гарын үсэг дутуу, анхан шатны санал хураалтын хүрээнд өрхүүдэд хангалттай саналын хуудсыг хүргүүлээгүй, эрэмбэлсэн саналын тоо иргэдээс ирүүлсэн саналын тооноос зөрүүтэй, бүлгийн ярилцлагын саналаа хурлын тэмдэглэлд бичигдээгүй байхад ямар ч баримтгүйгээр

шууд нэмдэг зэрэг зөрчлүүд гарсан нь "Төсвийн тухай", "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулиуд, Орон нутгийн хөгжлийн сангийн журам болон бусад хууль тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа бүрэн гүйцэд мөрдөж ажиллаагүйтэй холбоотой байна.


Долоо. Цаашид анхаарах асуудлын талаар

1. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллах;
2. Тендерийн үйл ажиллагааг хууль, журмын хүрээнд чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэх;
3. Тендерийг шалгаруулах үнэлгээний хороонд ажиллаж байгаа гишүүд ашиг сонирхлын зөрчилгүй мэдэгдлийг гарган, үнэлгээний хороог томилсон удирдах албан тушаалтнаар баталгаажуулалтыг хийлгэж хэвших;
4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын санал авахдаа саналын хуудсыг тэгш хүртээмжтэй байдлаар тарааж, саналын хуудсанд мэдээллийг бүрэн гүйцэд бөглүүлэх;
5. Иргэдээс ирсэн саналын хуудасны боловсруулалтыг бодитойгоор хийж, саналыг эрэмбэлж байх. Бүлгийн ярилцлага, ИНХ дээр ирүүлсэн иргэдийн саналыг баримтжуулж, хурлын тэмдэглэлд тусгах;
6. Захиалагч байгууллага болон техникийн хяналт хэрэгжүүлэх эрх бүхий этгээд тухайн ажлын явц, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах, хийсэн ажлын тайланг бичиж баталгаажуулж байх;

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН
АЛБАНЫ ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ  Н.ЛХАМДОЛГОР

ТАНИЛЦУУЛГА БИЧСЭН:

АУДИТОР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  Б.ПҮРЭВСҮРЭН

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН:

СУМЫН ЗАСАГ ДАРГА  М.МӨНХБАЯР
НЯГТЛАН БОДОГЧ  Г.АНХТӨР